

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орцуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Баруун болон Төв Африкийн эмэгтэйчүүдэд зориулсан залбирал 1

Баруун болон Төв Африкийн 23 улсын нэг болох Кот-д'Ивуар 2011 онд иргэний дайн дууссанаас хойш харьцангуй тогтвортой байна. Гэсэн хэдий ч сүүлийн хэдэн жилийн хугацаанд харгис хүчирхийлэл, улс төрийн тогтворгүй байдал, цагауурын өөрчлөлт, хүчгүй засаглал, нэн ядуурал, нийгмийн эмзэг бүлэг, нүүлгэн шилжүүлэн суурьшсан иргэдийн дунд маш удаан үргэлжилсэн хямрал тулгараад байна. Кот-д'Ивуар дахь "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвэрүүлэг долоо хоног бүр орон нутгийн радио станцуудаар цацагдаж, Face book болон бусад медиа хэрэгслээр манай багаар дамжуулан олон нийтэд хүрч байна. Үймээн самуун дунд байгаа эмэгтэйчүүдэд Бурханыг таниулахын төлөө Кот-д'Ивуар дах үйлчлэлийн багуудын төлөө хамтдаа залбирцгаа.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Эзэн минь, хүний наймааны эсрэг тэмцэж байгаа байгууллагуудыг Та нэгтгэжтэдний хоорондын харилцааг бэхжүүлж, үр нөлөөтэй үйлчлэхэд нь Та туслах болтугай. (Флп. 2:2)
2. Бурхан минь, итгэлийнхээ төлөө хавчигдаж, нөхөр, гэр бүлдээ хаягдсан Бенин дэх эмэгтэйчүүдийг Та хүчирхэгжүүлээч. Тэд чамайг чанга атгах болтугай. (1 Петр. 3:14)
3. Аав аа, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад жирэмсэн эхнэрээ хаясан нөхрүүд эргэн ирж эхнэрээ асран халамжилж, гэр бүлээ хайраар авч явах болтугай. (Еф. 5:25)

4. Бурхан минь, Кот-д'Ивуар дахь ганц бие эмэгтэйчүүд ур чадвар эзэмшиж, гэр бүлийн хэрэгцээгээ хангахуйц тогтвортой ажлын байртай болох болтугай. (Дуу. 90:17)
5. Эзэн минь, Габоны удирдагчид улс орныхоо байгалийн баялгийг зөв зохистой захиран зарцуулж, баялгийг нь зөв зарцуулах мэргэн ухаан хайрлаач. (Сур. 2:6)
6. Аав аа, Либерии улсад бэлэвсэн эмэгтэйчүүдийг сүнслэгээр урамшуулж, сэтгэл санааг нь тайтгаруулж, эдийн засгийн тогтвортой байдлыг олж авахад нь туслах сүнслэг итгэгчдийг Та илгээгээч. (Дуу. 68:5)
7. Эзэн минь, Малид гэрлэх гэж буй Христэд итгэгчдийг Танаас өгөх ханна хүлээхэд Та тэднийг урамшуулаарай. Тэдний гэрлэлт Таныг алдаршуулах болтугай. (2 Кор. 6:14)
8. Аав аа, Нигерийн залуучуудыг амархан баяжих гэсэн буруу үйлдлүүдээс Та хамгаалаач. Зөвхөн Танд байгаа жинхэнэ баялгийг хүсэхэд нь Та тэдэнд туслах болтугай. (Мат. 6:19-21)
9. Бурхан минь, Сенегал дахь сүмийн гишүүд TWR-ийн Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэлийг хүлээн авч, дэлхийн бүхий л эмэгтэйчүүдийн төлөөх залбиралын хуанлиг хүлээн авч нэгдэх болтугай. (Кол. 4:2)
10. Аав аа, Бенин дэх олон эмэгтэйчүүдийг холбодог архи, хар тамхи, садар самуун явдлын гинжийг Та таслаач. Тэд Танаас сүнслэг эрх чөлөөг олж авах болтугай. (Дуу. 72:12)
11. Бурхан минь, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад гэр бүл нь боол мэт дорд ханддаг эмэгтэйчүүд Танд итгэж, Танаас эрх чөлөө, хүч чадлыг олж авах болтугай. Тэдний сүнсийг сэргээгээч! (Дуу. 23)
12. Эзэн минь, Кот-д'Ивуар дахь ажил хийдэг эмэгтэйчүүдэд гэр бүл болон ажлаа хэрхэн зэрэгцүүлэн авч явах мэргэн ухааныг Та өгөх болтугай. (Сур. 3:5)
13. Аав аа, Габоны иргэдийн дунд эв найрамдал, эв нэгдэл бий болж, санал зөрчилдөөнөө энхийн замаар шийдвэрлэх болтугай. (1 Петр 3:8)
14. Эзэн минь, бид Либерийн эдийн засгийн тогтвортой байдлын төлөө залбирч байна. Ард иргэдийн мэргэн ухаан, амар амгалан, хэрэгцээгээ Танаар хангагдах болтугай. (Флп. 4:6-7)



15. Бурхан минь, Мали улсын ард түмэнд дайн, байгалийн гамшиг болон хүнсний хомсдолд нөлөөлж буй бусад хүчин зүйлсийг даван гарах хүчийг өгөөч хэмээн залбирч байна. (Флп. 4:19)
16. Аав аа, Нигерийн сүм чуулганыг хувиа хичээсэн ашиг хонжоо олохын тулд итгэгчдийг хууран мэхлэгч хуурамч пастор удирдагчдаас хамгаалах болтугай хэмээн залбирч байна. (Мат. 7:15–20)
17. Эзэн минь, орон гэргүй эмэгтэйчүүдэд туслахын тулд бодит тусламж шийлдлийг олоход нь Бенин дэх Христэд итгэгчдэд мэргэн ухааныг өгөөч. (Мат. 25:35)
18. Аав аа, Кот-д'Ивуар дахь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн гэрт амар амгалан, эдгэрэлийг өгөхийн төлөө бид залбирч байна. (Иохан 14:27)
19. Бурхан минь, Габон дахь Христэд итгэгчдийг Есүсийн төлөө зогсож, сайн мэдээг зоригтойгоор тунхаглах боломжийг олгооч, ингэснээр Таны Үг үндэстэн даяар тархах болтугай. (Еф. 6:19)
20. Эзэн минь, Либерид дэх манай үйлчлэл тэнд эмэгтэйчүүдэд боловсрол, ур чадвар олгох сургалтыг бий болгож байгаагийн төлөө бид Таныг магтъя. Эмэгтэйчүүдийн үйлчлэл цаашаа хөгжихийн тулд Эзэн Та ажиллах болтугай. (Сур. 9:9)
21. Аав аа, бид Танаас Мали улсын хот, тосгонд үерт нэрвэгдэгсдэд зориулсан хангамж, сүнслэг тусламж үзүүлэхийг хүмүүсийг тэдэн руу илгээхийн төлөө залбирч байна. (Дуу. 93:4)
22. Аав аа, Нигерт шударгаар захирч, авлигаас зайлсхийж, ард түмний зовлонг нимгэлэх бурханлаг удирдагчдыг Та өгөөч. (Египетээс гарсан. 18:21)
23. Эзэн Бурхан минь ээ, Кот-д'Ивуар дахь хосууд, ялангуяа Христэд итгэгчид салахын оронд эвлэрэхийг тэргүүнд тавиасай гэж бид залбирч байна. (1 Тес. 3:12)
24. Аав аа, Габоны ард түмний илүү сайн амьдралын төлөө Габоны удирдагчид эдийн засгийн хөгжлийн төлөө мэргэн ухаан, бүтээлчээр ард иргэдийнхээ амьдралыг сайжруудах болтугай. (Иер. 29:11)

25. Эзэн минь, энэ өвөл болох Мали дахь сайн мэдээний үйлчлэлд хамрагдсан бүх хүмүүсийг Сүнс дотор удирдан чиглүүлэх болтугай. Энэ үйлчлэлээр Таныг олон хүн таньж мэдэх болтугай. (Үйлс 28:31)
26. Бурхан минь, Нигерийн хүйсийн ялгаатай байдлаас болж хүчирхийлэлд өртөж, гадуурхагдаж, мөлжлөгт өртсөн эмэгтэйчүүдэд туслаач. (Дуу. 82:4)
27. Аав аа, Либерид дэх сүм чуулганууд сайн мэдээний төлөө хамтран зүтгэх болтугай. (1 Кор. 1:10)
28. Эзэн минь, бид Мали улсыг эзэлж буй гадны хүчний эсрэг тэмцэж байхдаа тэд Танаас амар тайван, эдгэрэл, тайвшралыг хүлээн авах болтугай. (Дуу. 27:14)
29. Бурхан минь, Габонд Христийн сүм чуулганыг хааж байгаа энэ үед Христэд итгэгчид, удирдагчдад мэргэн ухаан, ялгах чадварыг өгөх болтугай. (1 Кор. 12:27)
30. Эзэн минь, эхнэрээ санхүүгийн хувьд хангахыг хүсдэггүй Бенин улсын Холи омгийн эрчүүдийн зүрх сэтгэлийг өөрчилж, эмэгтэйчүүдийг ядуурлаас гаргах болтугай. (Дуу. 103:6)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Бурхан минь Монгол улсын боловсролын системд шинэчлэл хийгдэж, хүүхдүүд үнэнийг зааж, үнэн рүү хөтлөх болтугай. Христэд итгэгч багш нар шударга байдал болон энэрэнгүй байдлаа, итгэлээсээ ичихгүйгээр ажиллах болтугай.
2. Бурхан минь Монгол улсад өдөр өсөж байгаа өргөн хэрэглээний бараа, тог цахилгаан болон бусад хүний нэн тэргүүний хэрэгцээтэй зүйлсийн үнэ тогтвортой байхад Аав аа Та бүгдийг хяналтандаа авах болтугай.
3. Аав аа, бяцхан хүүхдүүдийг ханиад томууны дэгдэлтээс Та хамгаалаач.

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.